

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗАР

2020 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 01 дүгээр сарын 31

Дорнод аймаг

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, А/75 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэн, харьяатын газрын орон нутаг дахь газрын ажиллах журам” болон бусад хууль, тогтоомжид нийцүүлэн 2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийг хүртэл дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэ хугацаанд ОХУ-ын гарцтай Ульхан, Эрээнцав, БНХАУ-ын гарцтай авто замын Хавирга, Баянхошуу, Бичигт боомтууд хэлэлцээр ёсоор хуваарийн дагуу ажиллалаа. Тус хугацаанд 5 албан хаагч ажлын 3 хүртэлх хоногийн чөлөө авсан, 4-н албан хаагч ажлын 3-10 хоногийн эмчилгээний магадлагаатай байлаа.

Нэг. Захиргаа, удирдлага

Захиргаа удирдлагын газрын даргаар албан хаагчдын 1 дүгээр улиралд хилийн боомтод ажиллах хуваарийг батлуулан хуваарийн дагуу албан хаагчид ажиллаж байна.

Хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст газрын 12 дугаар сар, 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан, 1 дүгээр сарын төлөвлөгөөний биелэлт, инфо мэдээ, 02 дугаар сард хийх ажлын төлөвлөгөө, 2019 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулахаар хүргүүлсэн.

2019 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрүүдэд шинэ жилийн баяр болохтой холбоотойгоор амралтын олон хоногууд тохиож байсан тул тус өдрүүдэд аюулгүй байдлыг хангах үүднээс хариуцлагатай жижүүрийн хуваарь баталж ажилласан. Авилгын эсрэг хуулийн дагуу заасан ХАСХОМ бөглөх эрх бүхий тус газраас 14-н албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд нь бөглөж дууссан.

Албан хаагчдын ажлын үнэмлэх, ёс зүйн талоныг хураан авч төвд хүргүүлсэн.

Уулзалт, зөвлөгөөн, хамтын ажиллагаа. Даваа гараг бүрийн өглөө 8 цагт зохион байгуулагддаг Дорнод аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанд дарга, ахлах мэргэжилтэн нар сууж орон нутгийн талаарх мэдээ мэдээллийг авч ажиллаж байна.

2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Дорнод аймгийн Прокурорын газраас зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулж, уг зөвлөгөөнд хяналтын улсын ахлах байцаагч Б.Эрдэнэтуяа оролцсон.

2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Аймгийн Засаг даргын тамгын газарт Шинэ коронавирусийн халдвар тархаж байгаатай холбоотойгоор Аймгийн онцгой

комисс хуралдсан. Онцгой комиссын хуралдааны шийдвэрээр ажлын хэсэг байгуулагдан тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй буудлуудад хяналт шалгалт хийх чиглэл өгсөн.

Ажлын хэсэгт Гадаадын иргэн, харяатын газрын Зүүн бүс дэх газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Дорнод аймаг дахь Тагнуулын газар, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газар зэрэг нийт 7 байгууллага хамрагдаж хяналт шалгалтын ажлыг хамтран хийж гүйцэтгэсэн.

Сургалтад хамрагдсан талаар: Газрын дарга Б.Тамир, хяналтын улсын байцаагч Б.Ганзориг, мэргэжилтэн А.Нэмэхбаяр, жолооч Б.Ренчиндорж нар 12 дугаар сарын 23-наас 25-ны өдрүүдэд Улаанбаатар хотод байгууллагын 2019 оны жилийн эцсийн тайлангийн хурал, шинэ жилийн арга хэмжээнд оролцсон. Мөн Газрын дарга Б.Тамир, ахлах нягтлан бодогч Х.Хэрлэн урсгал, ХУБ Г.Хосбаатар, Б.Энхтулга, жолооч Б.Ренчиндорж нар 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 24-ны өдрүүдэд зохион байгуулсан “Удирдах албан тушаалтан, албан хаагчдын цугларалт, сургалт зохион байгуулах тухай” сэдэвт сургалтад хамрагдсан.

Бичиг хэргийн эргэлтийн талаар: Ирсэн бичиг: Байгууллагын удирдлагаас 2, бусад байгууллагаас нийт 11, нийт 13-н албан бичиг ирж, үүнээс хариутай 1 албан бичгийн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариуг хүргүүлсэн.

Явсан бичиг: Ажлын зохион байгуулалттай холбоотойгоор байгууллагын удирдах албан тушаалтанд явуулсан албан бичиг байхгүй албан бичиг, бусад байгууллагад 15 албан бичиг үйлдэж холбогдох байгууллагуудад явуулж мэдээ мэдээлэл солилцон ажилласан байна.

Өргөдөл: Тус сард албан хаагчдаас хувийн чөлөө хүссэн 5 өргөдөл хүсэлт хүлээн авч тухай бүр шийдвэрлэсэн.

Санхүүгийн талаар: 2020 оны 01 дүгээр сард 69,532,200.00 төгрөгийн санхүүжилтийг авснаас 36,730,564.64 төгрөгийн зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн хүрээнд зориулалтын дагуу хийж гүйцэтгэсэн.

2019 оны 12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 512,741,900.00 төгрөгийн санхүүжилт, 512,741,900.00 төгрөгийн гүйцэтгэлтэй, 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй гарсаныг газрын даргаар баталгаажуулан аймгийн төрийн сан болон ГИХГ-ын санхүү, хангалт, үйлчилгээний газарт хуулийн хугацаанд хүргүүлж ажилласан.

Хяналтын улсын байцаагч болон боомтын визийн хуудасны 12 дугаар сарын тайлангаар улсын тэмдэгтийн хураамж орлогод 59,293,000.00 төгрөг, хүү, торгуулийн орлогод 300,000.00 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Цалин хөлсний нийгмийн даатгалын 12 дугаар сарын тайлангаар нь нийт 27 албан хаагчдын 45,185,601.51 цалин, ногдол 10,538,385.03 төгрөг гарсаныг нийгмийн даатгалын санд шилжүүлж, цахимаар шивж цаасаар баталгаажуулсан.

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж шинэчлэгдсэн сайтанд 2019 оны 12 дугаар сарын мэдээллийг хуулийн хугацаанд шивж дуусгасан.

Сар бүр санхүүгийн ил тод байдлын самбарын мэдээллийг шинэчлэн албан хаагчдыг санхүүгийн мэдээллээр ханган ажиллаж байна.

Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд нь хүргүүлсэн.

Эд, хөрөнгө, хангалтын талаар: Газрын үйл ажиллагааны урсгал зардал, төлбөрийг 12-дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон Нийтийн аж ахуй, “ДБЭХС”, “Цахилгаан холбоо”, “Монгол шуудан”, “НИК”, “Санчир гэрэлтэх”, “Мэдээлэл холбоо”, “Ольхон” “Мянган айл” ХХК -тай тулгалтыг хийж тооцоо нийлсэн акт үйлдэн ажиллаа. Мөн Бүсийн газрын автомашины зам/км, шатахууны тооцоог гаргаж ахлах нягтлан бодогчид тайлагнасан.

“Өмч хамгаалах байнгийн зөвлөл” ийн гишүүдэд 05 дугаар хурлаар Бүсийн газрын 2019 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого, актлах хөрөнгө, тооллогын үр дүнгийн талаар танилцуулсан.

Бүсийн газрын даргын А/10 дугаар тушаалын дагуу аж ахуйн материалыг данс бүртгэлээс хасаж 2019 оны жилийн эцсийн эд хөрөнгийн нэгтгэлийг дахин гаргасан.

Хувцас хангалтын чиглэлээр өвлийн хүрэм өмд, хээрийн хүрэм өмд, аксалвантаар албан хаагч нарыг ханган ажилласан.

2019 оны жилийн эцсийн бараа материалын тайланг нэгтгэж анхан шатны баримтыг бүрдүүлж архивласан.

Бүсийн хэмжээнд “Галын аюулгүй байдал” –ыг хангахын тулд галын хор, үлээгүүр, гал хор тогтоогч зэргийг 1,729,000 төгрөгөнд худалдан авч боомт, төлөөлөл зэрэгт хүлээлгэн өгсөн.

Албан хаагчдаас ирүүлсэн хүсэлт, шаардах хуудасны дагуу принтерийн хор 21 ширхэг, бичгийн цаас 20 боодол, бичиг хэргийн материал 85 ширхэг, дугтуй, албан бланк виз бүртгэлийн дэвтэр зэргийг 1,530,090 төгрөгөнд, байгууллагын тохижилт үйлчилгээ, цэвэрлэгээ, сэлбэг, барилгын материал зэрэг 621 ширхэг 10,163,802 төгрөгний бараа материалыг худалдан авч холбогдох албан тушаалтан нарт шаардах хуудасны дагуу олгосон.

Бүсийн хэмжээнд албан хаагч нарынхаа эрүүл мэндийг урьдчилан хамгаалж сэргийлэх үүднээс витаминжуулах аяны хүрээнд чацаргана, нэрс, аньс, зэргийг 291,671 төгрөгөнд, амны хаалт, спирт, гар ариутгагч зэргийг 213,400 төгрөгөнд худалдан авч боомтод хүргүүлсэн.

Мэдээлэл, технологийн чиглэлээр: Тайлангийн хугацаанд Бүсийн газар болон харьяа хилийн боомтуудын сүлжээнд хяналт тавьж ажилласан. Тус хугацаанд Баянхошуу боомтын дотоод сүлжээ тасалдахад шуурхай арга хэмжээ авч засварлаж, хэвийн ажиллагаанд оруулсан.

Хилийн боомтод хуваарийн дагуу ажиллаж байгаа мэргэжилтэн А.Нэмэхбаяр, Б.Одмаа, Д.Оюунчимэг, Д.Оюунсүх нарын “ISM” системийн шилжүүлэх эрхийг бүртгэн авч, хяналт шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст танилцуулан тус програмын эрхийг шилжүүлсэн.

Хилийн боомтуудын дотоод сүлжээнд ашиглагдаж байгаа 9 ширхэг компьютерт Eset endpoint security антивирусны програмын лицензийг сунгаж 01 дүгээр сарын антивирусны програмын шинэчлэлтийг хийж ажилласан.

Төрийн албаны ил тод, нээлттэй байх, иргэдийг мэдээллээр хангах эрхийн дагуу www.immigration.gov.mn сайтын “Боомт орон нутаг” цэсэд 11 дүгээр сарын тайлан, төлөвлөгөөний биелэлт, 12 дугаар сарын төлөвлөгөөг шинэчлэн оруулсан.

Хяналтын улсын ахлах байцаагч Б.Эрдэнэтуяагийн Дэлл INSPIRON N50 маркийн нөөтбүүкнээс хортой код илэрсэн тул тус нөөтбүүкийг форматлаж хортой кодийг цэвэрлэж хэвийн ажиллагаанд оруулсан.

Үйлчилгээний танхимийн Дэлл T1700 компьютерийн эх хавтан шатсан тул засварлаж хэвийн ажиллагаанд оруулан албан хэрэгцээнд ашиглаж байна.

Үйлчилгээний танхимийн дотоод сүлжээ тасалдахад шуурхай арга хэмжээ авч сүлжээний тасралтгүй хэвийн байдлыг ханган ажилласан.

Монгол Улсад анх удаа хөдөлмөр эрхлэхээр ирсэн нийт 6 гадаадын иргэний хурууны хээг “Transient card system” програмаар бүртгэн авч, мэдээллийн баазад оруулсан.

Хилийн боомтуудын хяналтын улсын байцаагч болон мэргэжилтэн нарт сүлжээ, “ISM” систем болон компьютер техникийн 8 удаагийн зөвлөгөө өгч ажилласан.

Хоёр. Виз, зөвшөөрлийн чиглэлээр

Хариуцсан хилийн боомтуудаар нийт 3 орны, гадаадын 4673 /БНХАУ, Хонг Конг, ОХУ/ иргэн улсын хилээр нэвтэрснээс орох чиглэлд 2046, гарах чиглэлд 2627 гадаадын иргэн нэвтэрсэн байна. Эдгээр иргэдээс БНХАУ-ын 320 иргэнд зохих ангилал, зориулалтын дагуу виз олгосон. Үүнд:

- “HG” ангиллын визийг 289 иргэнд олгосон. Үүнээс:
 - “гарах-орох” нэг удаагийн зориулалттай виз -125
 - “гарах-орох” хоёр удаагийн зориулалттай виз -8
 - “гарах-орох” олон удаагийн зориулалттай виз -133
 - Визийн шилжүүлэг- 23
- “H” ангиллын визийг 4 иргэнд олгосон. Үүнээс:
 - “гарах-орох” нэг удаагийн зориулалттай виз -3
 - “гарах-орох” хоёр удаагийн зориулалттай виз -1
- “S” ангиллын визийг 26 иргэнд олгосон. Үүнээс:
 - “гарах-орох” нэг удаагийн зориулалттай виз -26
- “B” ангиллын визийг 1 иргэнд олгосон. Үүнээс:
 - Визийн шилжүүлэг- 1 нийт 320 иргэнд тус тус олгосон.

Виз сунгалт: Тайлант хугацаанд БНХАУ-ын нэг иргэнд “B” ангиллын нэг удаагийн “орох” зориулалтын визийн байх хугацааг 30 хоногоор сунгасан

Алдаатай визийн бүртгэл: Баянхошуу боомтод “HG” ангиллын визийг оршин суух зөвшөөрлийн хугацаанаас хэтрүүлэн олгосон байсан тул шинээр дахин виз олгосон.

Түр ирэгчийн бүртгэл -5, хасалт-1

Бүсийн төвд: Дорнод их Сургуулийн албан хүсэлтээр “S” ангиллын визтэй БНХАУ-ын 4 иргэн, хувь хүний хүсэлтээр “B” ангиллын нэг удаагийн “орох” зориулалтын визийн сунгалт 1 нийт 5 иргэнийг түр ирэгчийн бүртгэлд бүртгэж, “B”

ангиллын нэг удаагийн “орох” зориулалтын визийн сунгалт хийсэн 1 иргэнийг түр ирэгчээс тус тус хасалт хийсэн байна.

Оршин суух зөвшөөрлийн хасалт: Бүсийн төвд 1 аж ахуйн нэгжийн албан хүсэлтээр БНХАУ-ын хөдөлмөр эрхлэх ОСЗ-тэй 12 иргэн, Бичигт хилийн боомтод 1 аж ахуйн нэгжийн албан хүсэлтээр БНХАУ-ын хөдөлмөр эрхлэх ОСЗ-тэй 23 иргэн, Хавирга хилийн боомтод 1 аж ахуйн нэгжийн албан хүсэлтээр БНХАУ-ын хөдөлмөр эрхлэх ОСЗ-тэй 2 иргэн нийт 37 иргэний оршин суух зөвшөөрөлд хасалт хийсэн.

ХОНДЗҮ-ээр хил нэвтэрсэн БНХАУ-ын 84 иргэнийг бүртгэж, 123 иргэнийг хассан.

Хурууны хээ: Монгол Улсад анх удаа ирсэн гадаадын 6 иргэний хурууны хээг “Transient card system” програмаар бүртгэн авч, мэдээллийн баазад оруулсан.

Хувийн урилга: Тайлант хугацаанд хувийн урилга олгоогүй.

Зөвөлгөө мэдээлэл: 57 иргэнд зөвөлгөө мэдээлэл өгсөн. Үүнээс:

- Хавирга боомтод: БНХАУ-ын 24 иргэнд виз, визийн ангилал төрөл, зориулалтын талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн.

- Бичигт боомтод: БНХАУ-ын 14 иргэнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, виз, визийн ангилал төрөл, зориулалтын талаар;

- Баянхошуу боомтод: БНХАУ-ын 4 иргэнд;

- Бүсийн төвд 15 иргэн, аж ахуйн нэгжид виз, визийн ангилал, түр ирэгчийн талаар зөвлөгөө өгсөн.

Ярилцлага хийсэн бүртгэл: 51

- Хилийн боомтуудад БНХАУ-ын 51 иргэний виз Монгол Улсад зорчих зорилготой нийцсэн эсэх талаар ярилцлага хийн тэмдэглэл хөтөлсөн. Үүнд: Баянхошуу боомтод 5 иргэн, Бичигт боомтод 10, Бүсийн төвд 5, Хавирга боомтод 31 иргэнтэй тус тус ярилцлага хийсэн.

Сүлжээний хяналт: ОХУ-д гарцтай Ульхан, Эрээнцав, БНХАУ-д гарцтай авто замын Хавирга, Баянхошуу, Бичигт боомтуудад хилээр зорчсон 3 орны 4673 иргэний хөдөлгөөнд хяналт тавьж, 2046 гадаадын иргэний мэдээллийг “ISM” сүлжээнд шалган нэвтрүүлсэн.

Гурав. Хяналт шалгалтын чиглэлээр

Тус газар нь нэгдүгээр сарын тайлангийн хугацаанд Бүсийн газрын даргын баталсан №12/05-2020/01 тоот удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт, Аймгийн онцгой комиссын шийдвэрээр ажлын хэсэг байгуулагдаж төлөвлөгөөт бус 1, нийт 2 удаагийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтанд нийт 3 аж ахуй, нэгжийн гадаадын 7 /БНХАУ-ын 5, АНУ-ын 2/ иргэн хамрагдсан. Шалгалтаар илэрсэн зөрчилгүй.

Тайлангийн хугацаанд Бүсийн хэмжээнд 2 зөрчлийг илрүүлж, 1 аж ахуй нэгжийн 2 иргэнд 560.000.00 /таван зуун жаран мянга/-н төгрөг, хувь хүнээр 1 иргэнд 100.000,0 /нэг зуун мянга/-н төгрөг, нийт 660.000.00 /зургаан зуун жаран мянга/-н төгрөгийн торгуулийн арга хэмжээг ногдуулж ажилласан.

Хил дээрээс буцаагдсан иргэдийн талаар: Хавирга боомтод ГИЭЗБТХ-ийн 22.1.6 дахь заалтыг үндэслэн БНХАУ-ын 2 иргэн, Бичигт боомтод ГИЭЗБТХ-ийн

22.1.6 дахь заалтыг үндэслэн БНХАУ-ын 7 иргэн, нийт 9 иргэнийг орох чиглэлд хилээр нэвтрүүлэлгүй буцаасан.

Албадан гаргалтын талаар: Хяналтын улсын ахлах байцаагч Н.Дуламсүрэнгийн чиглэл өгсөний дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн QIQIGE / 1984.12.22-нд төрсөн, эмэгтэй, E91775641 дугаарын паспортай/-ийг Бүсийн төвд хурууны хээг авч Хавирга боомтоор албадан гаргаж, албадан гаргасан тодорхойлолтыг шуудангаар хүргүүлж ажилласан.

Албан шаардлага хүргүүлж ажилласан талаар: Албан шаардлага хүргүүлсэн аж ахуй нэгж байхгүй.

Байгууллагын даргын №04 албан даалгаврын хүрээнд:

1. Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан эрх зүйн хэлбэрийг зааврын дагуу үйлдэж зөрчил тус бүрд дугаарлалтыг өгч ажилласан.

2. Тайлангийн хугацаанд Бүсийн төвд 2 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн. Зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж харьяа Прокурорын газрын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, хяналтанд оруулах ажиллагааг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.

Байгууллагын даргын 2019 оны 03 тоот албан даалгаврын хүрээнд:

1. Бүсийн хэмжээнд нийт 38 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж нийт 6,310.000.0 /зургаан сая гурван зуун арван мянга/-н төгрөгийн торгуулийн шийтгэл ногдуулж, зөрчлийг шийдвэрлэсэн байна. Хяналт шалгалтын явцад Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.7 дахь заалтыг зөрчсөн БНХАУ-ын 6 иргэн, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн БНХАУ-ын 1 иргэнийг, нийт 7 иргэнийг Монгол Улсаас албадан гаргаж, 10 хоногийн хугацаанд Монгол Улсаас гарсан эсэхэд хяналт тавьж хуулийн хугацаанд Монгол Улсаас гарсан байна.

2. Бүсийн төвд “Ганхийц” ХХК-ийн хүсэлтээр БНХАУ-ын 12 иргэнд, Бичигт боомтод “Аэдэ” ХХК-ийн хүсэлтээр 12 иргэн, “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн хүсэлтээр БНХАУ-ын 11 иргэн, “Хавирга” боомтод “Ган-хийц” ХХК-ийн хүсэлтээр БНХАУ-ын 2 иргэнд нийт 37 иргэнд оршин суух зөвшөөрөлд хасалт хийсэн. Дээрхи иргэд нь хасалтын хугацаанд Монгол Улсаас гарсан болно. Тайлангийн хугацаанд гадаадын хөрөнгө оруулалттай “Петрочайна Дачин тамсаг” ХХК-ийн БНХАУ-ын 24 иргэн хилээр хасалт хийгээгүй гарсан мэдээллийг виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Б.Ганзоригт гарган өгч, хасалтыг нөхөж хийсэн.

3. Бүсийн даргад аймгийн хэмжээнд оршин сууж буй гадаад иргэдийн мэдээллийг гаргаж өгч, оршин суух зөвшөөрөл аваагүй, оршин суух зөвшөөрлийн хугацаа хэтэрсэн иргэдийн талаар танилцуулж, оршин суух зөвшөөрөл хугацаандаа аваагүй БНХАУ-ын 2 иргэний зөрчлийг арилгуулж ажилласан.

ТАНИЛЦСАН.

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ,
ДОТООД АУДИТ, ОРОН
НУТГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАТСҮХ

ХЯНАСАН.
ЗҮҮН БҮС ДЭХ
ГАЗРЫН ДАРГА

Б.ТАМИР

ТАЙЛАН БИЧСЭН.
МЭРГЭЖИЛТЭН

А.НЭМЭХБАЯР